



**"ГЕРМЕС ЦЕНТР"  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН  
МЭДЭЭЛЭЛ**

**2018 ОН**

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Дарга Д.Оюунсүрэн

Гүйцэтгэх захирал

Б.Оюунцэцэг

Нягтлан бодогч О.Энхтуяа

ТУЗ-ийн нарийн бичгийн  
дарга Д.Эрдэнэсүрэн

АУДИТЫН  
ХОРОО

/Хараат бус гишүүд/

Д.Туяа

Н.Батсайхан

Б.Алтангэрэл

ЦАЛИН  
УРАМШУУЛЛЫН  
ХОРОО

Д.Оюунсүрэн

Д.Алтанчимэг

Н.Мөнхзул

НЭР ДЭВШҮҮЛЭХ  
ХОРОО

Б.Оюунцэцэг

Ц.Түвшинжаргал

Б.Амарсанаа

## КОМПАНИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн оноосон нэр:	“Гермес Центр” ХК
Үйл ажиллагааны чиглэл	Түрээс
Компанийн албан ёсны хаяг:	Баянгол дүүрэг, 4-р хороо, Нарны зам 20,20-1
Компанийн эрх барих дээд байгууллага :	Хувьцаа эзэмшигчдийн хурал
Үүсгэн байгуулагдсан огноо:	2003 оны 07-р сарын 22-ны өдөр
Ажиллагсдын тоо:	16
Хувьцааны тоо :	78 543 001
Холбоо барих утас:	11 – 30 – 15 – 77
Вэб хуудас:	<a href="http://www.hermescenter.mn">www.hermescenter.mn</a>

## “ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Тус компани нь өнгөрсөн 2018 онд нийт 16 ажилтан ажилласадтайгаар Гермес барилгын материалын худалдааны төвийн үйл ажиллагааг явуулж ажиллалаа.

Компани 2018 онд батлагдсан хөрөнгө оруулалтын төсвийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд :

- Худалдааны төвийн "Б" корпусын дээвэрт агаар сорох 8 ширхэг салхин сэнс буюу диффлекторыг, 1, 2-р давхруудад агаар өгөх 4 ширхэг сэнсийг нийт 7.1 сая төгрөгөөр угсарч суурилуулсан.
- Худалдааны төвийн "Б" корпусын дээврийг будах, гадна фасадыг иж бүрэн шинэчлэх засварлах ажлыг 16.4 сая төгрөгийн зардлаар хийж гүйцэтгэсэн.
- Худалдааны төвийн "А", "Б" корпусын 1, 2, 3, С давхруудад галын хор, гамшгийн үеийн аврах гарцийн бүдүүвч самбар, түрээслэгчдэд зориулсан мэдээллийн самбаруудыг шинээр байршуулсан.

Компанийн санхүүгийн үндсэн үзүүлэлтийн тухай : Компанийн нийт хөрөнгө 8 398.6 сая төгрөг бөгөөд үүнээс :

- Эргэлтийн хөрөнгө 1 721.3 сая төгрөг
- Үндсэн хөрөнгө 4 388.9 сая төгрөг
- Биет бус хөрөнгө 2 288.5 сая төгрөг
- Эзэмшигчийн өмч хөрөнгө 7 854.3 сая төгрөг
- Татварын дараах цэвэр ашиг 783.4 сая төгрөг байна.

2. Татвар төлөлтийн тухай: Компани 2018 онд улсад нийтдээ 397.8 сая төгрөгийн татварыг төлөөд байна. Үүнд:

- ААН-ийн ОАТатварт 86.2 сая төгрөг
- НДШимтгэлд 30.0 сая төгрөг
- Ажиллагсдын цалингаас суутгасан хувь хүний ОАТатварт 20.3 сая төгрөг
- НӨАТатварт 121.1 сая төгрөг
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт 57.4 сая төгрөг
- Ногдол ашгийн татварт 78.5 сая төгрөг
- Газрын төлбөр 4.3 сая төгрөг

### 3. Орлогын үр дүнгийн тухай :

Компани 2018 онд нийтдээ 1 572.6 сая төгрөгийн орлоготой ажилласан. Жилийн эцсийн дүнгээр орлогын нийт дүн төсөвлөсөн 1502.7 сая төгрөгийн орлогын дүнтэй харьцуулахад 104.7%-ийн биелэлттэй байна. Төлөвлөснөөс 69.9 сая төгрөгөөр давуулсан.

### 4. Зардлын тухай :

Компани 2018 онд 789.2 сая төгрөгийн зардалтай ажилласан. Зардлын төлөвлөгөө 844.4 сая төгрөг байсантай харьцуулахад төлөвлөгөөний биелэлт 93%-тай гарсан. Компанийн хэмжээгээр зардлыг төсөвлөснөөс 55.2 сая төгрөгөөр хэмнэж ажилласан.

### 5. Ашгийн тухай

Компани 2018 оны эцэст 783.4 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан. Ашгийн төлөвлөгөө 658.3 сая төгрөг байсантай харьцуулахад төлөвлөгөөг 119%-иар буюу 125.1 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажилласан. Компани нь нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн төлөвлөгөөг дараах байдлаар биелүүлсэн. Үүнд :


- 2018 оны нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн төлөвлөгөө 8 төгрөг 38 мөнгө байсан бол санхүүгийн тайлангаар нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 9 төгрөг 97 мөнгө болж, төлөвлөгөөг 19%-иар давуулсан.

## ТҮРЭЭСИЙН ТАЛБАЙН ҮНЭ ТАРИФ /₮/


	2015	2016	2017	2018	2019
Лангуу	150 000	150 000	150 000	150 000	150 000
2-р давхар, С давхар, оффис	20 000	18 000	17 000	17 000	18 000
1-р давхар /павильон/	25 000	21 000	20 000	20 000	20 000

Жич: Оны эхний 1, 2, 3-р саруудад түрээсийн төлбөрт 10%-ийн хөнгөлөлт үзүүлсэн.

## КОМПАНИЙН НИЙТ ХӨРӨНГӨ /сая ₮ /




## НИЙТ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /сая ₮/







## ОРЛОГЫН БҮТЭЦ -2018 ОН /нийт 1,572.6 сая төгрөг/



## ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /сая ₮/



## ЗАРДЛЫН БҮТЭЦ-2018 ОН /нийт 789.2 сая ₮/



■ Цалин - 250.7 сая

■ Ашиглалтын зардал - 133.5 сая


■ Элэгдлийн зардал - 161.3 сая

■ Материалын зардал - 29.4 сая


■ Татварын зардал - 178.9 сая

■ Бусад зардал - 35.4 сая

## ЦЭВЭР АШГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /сая ₮/



## НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /₮/




## КОМПАНИЙН СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ


₮

№	Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
1	Эргэлтийн хөрөнгө	1,325,128,405.94	1,403,086,689.58	1,541,179,226.10	1,678,326,249.34	1,721,276,038.37
2	Эргэлтийн бус хөрөнгө	7,097,247,925.97	7,035,735,803.31	6,861,584,941.56	6,805,624,589.59	6,677,378,101.86
3	Нийт хөрөнгө	8,488,868,524.94	8,438,822,492.89	8,402,764,167.66	8,483,950,838.93	8,398,654,140.23
4	Нийт өр төлбөр	216,289,390.23	219,610,530.09	209,455,277.50	198,987,075.45	213,651,174.42
5	Эзэмшигчдийн өмч	8,206,086,941.68	8,219,211,962.80	8,193,308,890.16	8,284,963,763.48	8,185,002,965.81
6	Борлуулалтын орлого	1,367,026,698.85	1,494,879,283.52	1,367,696,294.36	1,334,591,010.34	1,389,183,726.83
7	Нийт орлого	1,624,419,855.04	1,569,335,970.52	1,489,906,907.10	1,490,397,917.45	1,572,606,312.34
8	Нийт зардал	807,978,457.68	830,946,635.87	817,376,753.65	774,988,602.67	789,189,311.26
9	Ашгийн татвар	89,782,013.92	82,031,240.65	78,299,294.78	79,488,786.45	87,046,333.45
10	Цэвэр ашиг	816,441,397.36	738,389,334.65	672,530,153.45	715,409,314.78	783,417,870.81
11	EPS /Нэгж хувьцаанд ногдох ашиг/	10.39	9.4	8.56	9.11	9.97
12	PE /Үнэ ашгийн харьцаа/	16.35	13.04	19.84	15.59	14.04
13	ROE /Хувьцаат капиталын өгөөж/	0.1	0.09	0.08	0.09	0.1
14	BV /Нэгж хувьцаанд ногдох дансны үнийн харьцаа/	1.7	1.23	1.7	1.42	1.4

## КОМПАНИЙН НИЙТ ОРЛОГЫН ХЭМЖЭЭ /сая ₮/




## КОМПАНИЙН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ /сая ₮/






## КОМПАНИЙН НИЙТ ТАТВАРЫН ХЭМЖЭЭ /сая ₮/




## КОМПАНИЙН ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ /сая ₮/




## 2008 – 2018 ОНУУДАД ТАРААСАН НОГДОЛ АШИГ

"Гермес центр" ХК нь Монголын хөрөнгийн бирж дээрх хамгийн идэвхитэй ногдол ашиг тараадаг компаниудын нэгэн бөгөөд хувьцаа эзэмшигчдэдээ 2008 оноос эхлэн ногдол ашиг тарааж ирсэн.



## КОМПАНИЙН НЭГЖ ХУВЬЦААНД ХУВААРИЛСАН НОГДОЛ АШИГ /₮/




## ХУВЬЦААНЫ ХАНШ 2008 – 2018 ОН /₮/

### *Хувьцааны зах зээлийн үнэлгээ*


"Гермес Центр" ХК нь Монголын хөрөнгийн бирж дээр 2 дугаар ангиллын компанид багтдаг бөгөөд 2018 оны 12 дугаар сарын байдлаар зах зээлийн үнэлгээ 11.0 тэрбум төгрөг болсон .

### *Хувьцааны ханшийн өөрчлөлт*

2018 оны байдлаар нэгж хувьцаа хөрөнгийн зах зээл дээр 140 төгрөгөөр арилжаалагдаж байсан бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө 1.4 дахин өссөн.



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



Нийт хувьцааны тоо

**78 543 001**

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо

**911**

■ Д.Зоригт

■ Д.Оюунсүрэн

■ "Impera Mongolia" ХХК

■ Бусад

## “ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2018 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурлыг 2019 оны 03-р сарын 07-ны өдрийн 15:00 цагт компанийн төв байрны 3 давхрын хурлын танхимд амжилттай зохион байгууллаа. Хуралд нийт 67 642 521 ширхэг саналын эрхтэй 27 хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирж оролцлоо. Хурлын ирц 86.12%-тай байлаа.

Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

- Компанийн 2018 оны бизнесийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% сайшаав.
- Компанийн 2018 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100 % сайшаан тэмдэглэв.
- Компанийн 2017 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2018 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2019 оны ногдол ашгийн тухай мэдээллийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид сонсож 100% дэмжив.
- Компанийн 2018 оны ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшууллын зардлын гүйцэтгэлийг хувьцаа эзэмшигчдэд тайлагнаж, 2019 оны ТУЗ-ийн зардлыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталлаа.
- Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай мэдээллийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.
- Компанийн 2019 оны үйл ажиллагааны зорилтыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100 % дэмжив.

## “ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2017 , 2018 ОНЫ НОГДОЛ АШИГ ХУВААРИЛЖ ТАРААСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Хамрах хугацаа: 2017- 2018 он

Ногдол ашиг зарласан огноо		Нэгж хувьцаанд хуваарилсан ногдол ашиг (төг)	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Нийт ногдол ашгийн дүн (төг)	Ногдол ашиг олгосон хэлбэр		Ногдол ашиг тараалтын хувь
					Компани дээр бэлнээр	ҮЦТХТөвөөр дамжуулан бэлэн бусаар	
2017	Эхний хагас жил	3.81	942	300.0 сая	256.6 сая	42.7 сая	100%
	Сүүлийн хагас жил	5	923	392.7 сая	336.7 сая	55.9 сая	100%
Нийт		8.81		692.7 сая			
2018	Эхний хагас жил	5	910	392.8 сая	336.8 сая	55.8 сая	100%
	Сүүлийн хагас жил	3.8	911	298.4 сая	256.5 сая	41.9 сая	100%
Нийт		8.8		691.2 сая			

## “ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2019 ОНЫ НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2019 онд хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг дээдэлж, 2019 оны санхүүгийн тайланд 2 удаа аудитын дүгнэлт гаргуулж, ногдол ашгийг өмнөх жилүүдийн адилаар оны хагас болон бүтэн жилээр хоёр удаа хуваарилах саналтай байгааг хувьцаа эзэмшигчдэдээ мэдэгдэхэд таатай байна.



## **“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН 2018 ОНД ГАРСАН ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ЗАРДАЛ**

“Гермес центр” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь дараах зардлыг гаргаж зарцуулсан болно. Үүнд :

- Цалингийн зардал нийт 12.5 сая төгрөг
- ТУЗ-ийн гишүүн нь хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 350 000 төгрөгийн цалин авдаг. Хуралд оролцоогүй тохиолдолд цалин олгодоггүй болно.
- Компанийн гүйцэтгэх захирлын цалин урамшууллын зардалд нийт 55.6 сая төгрөг зарцуулсан.

## **“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН 2019 ОНЫ ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ**

“Гермес центр” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2019 онд дараах цалингийн санг өмнөх оны төсвөөр батлуулахаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулж байна. Үүнд:

- ТУЗ-ийн дарга хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 410 000 төгрөгийн цалин олгох – улиралд 1 удаа хуралдана.
- ТУЗ-ийн гишүүн хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 350 000 төгрөгийн цалин олгох – улиралд 1 удаа хуралдана.
- Цалингийн нийт зардал 4 улирлаар тооцоход 12.8 сая төгрөг
- Компанийн Гүйцэтгэх захирлын цалин урамшууллын зардал 56.2 сая төгрөг байна.

# “ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД БОЛОН ТЭДГЭЭРИЙН ЭЗЭМШИЛД БАЙГАА ХУВЬЦААНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Компанийн нэр: “Гермес Центр” ХК

Компанийн гаргасан хувьцааны тоо: 78 543 001

Мэдээлэл гаргасан огноо: 2019 оны сүүлийн хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр буюу 2019 оны 02-р сарын 18-ны өдрийн байдлаар

	Нэгдмэл сонирхолтой этгээдийн овог нэр	Эрхэлж буй албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны	
			Тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Дашзэвэг овогтой Зоригт	Иргэн	42 530 145	54.10%
2	Дугаржав овогтой Оюунсүрэн	"АСУ" сургуулийн захирал	23 460 015	29.80%
Нийт			65 990 160	83.90%

# “ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ

## *“Ая тухыг эрхэмлэгч” барилгын материалын худалдааны төв*

- Нэгдүгээрт : Худалдан авагчдын эрх ашгийг дээдэлж, ая тухтай үйлчилж
- Хоёрдугаарт : Түрээслэгчдийн эрх ашгийг дээдэлж, тэднийг ажиллах нөхцлөөр хангаж
- Гуравдугаарт : Ажиллагсдын эрх ашгийг хамгаалж, нийгмийн асуудлыг шийдвэрлэж
- Дөрөвдүгээрт : Хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцааны өгөөжийг нэмэгдүүлж ажиллана.

### *Компанийн орлогын тухай:*

Тус компани нь 2019 оны эцэст 1 606.5 сая төгрөгийн цэвэр орлоготой ажиллана.

### *Компанийн зарлагын тухай*

Компанийн хэмжээгээр 2019 онд төсөвлөснөөр 772.4 сая төгрөгийн зардалтай ажиллана.

### *Компанийн ашигийн тухай*

Татварын дараах цэвэр ашиг төсөвлөснөөр 750.7 сая төгрөг байна.

### *Компанийн нэгж хувьцаанд хуваарилах ашигийн тухай*

“Гермес центр” ХК-ийн нэгж хувьцаанд 9 төгрөг 56 мөнгөний ногдол ашиг оногдохоор төлөвлөсөн.

### *Компанийн бүтэц зохион байгуулалтын тухай*

Компани нь 16 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулна.